



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хангал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/87/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Булган хот 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70342580 Цахим хаяг: Anhbayrd@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enhtsoodol@audit.gov.mn</p> <p>Аудитор: А.Сувдаа Утас: 70342495 Цахим хаяг: Suvdaaa@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Залруулсан алдаа.....	18
4.2 Төлбөрийн акт.....	18
4.2Албан шаардлага	18
4.3 Зөвлөмж	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НА	Нийцлийн аудит
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 82

танай _____ ны № _____ т

ХАНГАЛ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА И.ТУЛГА
ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хангал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хангал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


D:/bichighereg/2022A4toot

006020136

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>34,670,786.79</u>	<u>124,992,241.79</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	1,764,449.10
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	1,764,449.10
3121	Төгрөг	-	1,764,449.10
31211	Төрийн сангийн харилцах	-	901,042.99
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	863,406.11
33	АВЛАГА	-	55,326,094.18
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	601,594.18
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	54,724,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	34,670,786.79	67,901,698.51
351	Түүхий эд материал	3,105,589.61	20,356,430.72
35130	Эм боох материал	3,105,589.61	20,356,430.72
354	Хангамжийн материал	31,565,197.18	47,545,267.79
35410	Бичиг хэргийн материал	1,766,582.00	1,721,234.00
35420	Аж ахуйн материал	17,551,922.00	32,577,362.00
35430	Сэлбэг хэрэгсэл	9,201,100.00	8,561,100.00
35440	Түлш, шатах тослох материал	-	1,595,230.00
35450	Барилгын засварын материал	229,500.00	-
35460	Хүнсний материал	878,988.49	1,273,480.60
35470	Бусад хангамжийн материал	1,937,104.69	1,816,861.19
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>307,603,447.43</u>	<u>308,364,540.30</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	307,603,447.43	308,364,540.30
392	Биет хөрөнгө	296,303,447.43	295,714,540.30
39201	Барилга, байгууламж, орон сууц	427,954,516.42	427,954,516.42
39202	Хуримтлагдсан элэгдэл	(216,132,468.16)	(225,501,159.32)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	31,372,000.00	31,372,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(11,909,333.22)	(17,137,999.86)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	71,345,444.93	97,167,352.46
39206	Хуримтлагдсан элэгдэл	(25,149,640.90)	(33,060,018.70)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,393,676.14	21,393,676.14
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,709,811.70)	(9,202,869.40)
39209	Зам, гүүрийн байгууламж	3,333,318.00	-
39210	Хуримтлагдсан элэгдэл	(624,254.08)	-
39214	Бусад үндсэн хөрөнгө	260,000.00	3,593,318.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(165,000.00)	(1,199,275.44)
39217	Ном	335,000.00	335,000.00
393	Биет бус хөрөнгө	11,300,000.00	12,650,000.00
39301	Програм хангамж	-	1,350,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	11,300,000.00	11,300,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>342,274,234.22</u>	<u>433,356,782.09</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>27,125,823.29</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	27,125,823.29
413	Өглөг	-	27,125,823.29
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	8,725,409.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	18,000,260.00
4136	Бусад өглөг	-	400,154.29

Хангал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	400,154.29
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	342,274,234.22	406,230,958.80
51	Засгийн газрын хувь оролцоо	342,274,234.22	406,230,958.80
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	180,430,094.87	180,430,094.87
51101	Өмч: - төрийн	3,141,263.98	3,141,263.98
512	Хуримтлагдсан үр дүн	4,051,265.30	68,007,989.88
51210	Өмнөх үеийн үр дүн	4,051,265.30	4,252,705.19
51220	Тайлант үеийн үр дүн	-	63,755,284.69
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	157,792,874.05	157,792,874.05
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	342,274,234.22	433,356,782.09

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон		/төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	332,437,831.06	664,581,968.83
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,183,341.06	143,064,523.83
120	Нийтлэг татварын бус орлого	19,183,341.06	143,064,523.83
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,755,259.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6,755,259.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,785,000.00	21,486,507.53
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	10,643,082.06	121,578,016.30
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	313,254,490.00	521,517,445.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	280,708,200.00	318,139,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	280,708,200.00	318,139,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,700,000.00	149,950,365.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	1,751,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,700,000.00	143,467,965.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	4,731,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	11,663,200.00	35,343,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	11,663,200.00	35,343,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	10,183,090.00	18,083,780.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	10,183,090.00	18,083,780.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	352,155,005.58	600,826,684.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	352,155,005.58	600,826,684.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	345,433,752.99	576,330,577.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	218,514,383.00	266,020,778.00
210101	Үндсэн цалин	136,369,857.00	173,420,314.00
210102	Нэмэгдэл	68,130,826.00	71,127,219.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	3,123,171.00
210104	Урамшуулал	14,013,700.00	18,350,074.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,216,914.91	33,510,764.90
210201	Тэтгэврийн даатгал	18,789,676.29	23,173,437.47
210202	Тэтгэмжийн даатгал	2,185,144.14	2,583,803.69
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,748,114.28	2,312,042.90
210204	Ажилгүйдлийн даатгал	408,545.04	494,680.12

Хангал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	4,085,435.16	4,946,800.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,558,347.47	32,264,293.00
210301	Гэрэл, цахилгаан	1,746,166.00	2,254,423.00
210302	Түлш, халаалт	14,812,181.47	29,707,870.00
210303	Цэвэр, бохир ус	-	302,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,662,786.13	23,990,066.50
210401	Бичиг хэрэг	1,191,368.00	2,828,900.00
210402	Тээвэр, шатахуун	6,889,173.53	10,028,935.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,086,800.00	1,698,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,264,350.00	2,948,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,640,975.60	6,012,831.50
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,590,119.00	472,700.00
2105	Нормативт зардал	33,848,066.12	186,620,669.08
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	29,313,410.32	180,960,791.19
210502	Хоол, хүнс	3,279,205.80	5,527,877.89
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,255,450.00	132,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,239,000.00	1,457,340.00
210604	Урсгал засвар	2,239,000.00	1,457,340.00
2107	Томилолт, зочны зардал	618,000.00	937,000.00
210702	Дотоод албан томилолт	618,000.00	937,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,759,913.00	125,950.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,164,653.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	98,010.00	54,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	32,250.00	38,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,016,342.36	31,403,715.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,248,528.00	4,992,901.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	16,767,814.36	26,410,814.66
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,721,252.59	24,496,107.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	24,488,500.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	23,688,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	800,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,721,252.59	7,607.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,721,252.59	7,607.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(19,717,174.52)	63,755,284.69
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,429,097.75	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,429,097.75	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(2,429,097.75)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(22,146,272.27)	63,755,284.69

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	180,430,094.87	157,792,874.05	4,051,265.30	-	342,274,234.22
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	201,439.89	-	201,439.89
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	63,755,284.69	-	63,755,284.69
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	180,430,094.87	157,792,874.05	68,007,989.88	-	406,230,958.80

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон		/төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	313,254,490.00	466,792,945.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	313,254,490.00	466,792,945.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	280,708,200.00	318,139,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	280,708,200.00	318,139,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,700,000.00	95,225,865.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	1,751,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,700,000.00	88,743,465.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	4,731,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	11,663,200.00	35,343,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	11,663,200.00	35,343,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	10,183,090.00	18,083,780.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	10,183,090.00	18,083,780.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	311,216,490.00	459,343,095.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	311,216,490.00	459,343,095.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	304,495,237.41	434,846,988.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	218,514,383.00	257,295,369.00
210101	Үндсэн цалин	136,369,857.00	164,694,905.00
210102	Нэмэгдэл	68,130,826.00	71,127,219.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	3,123,171.00
210104	Урамшуулал	14,013,700.00	18,350,074.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,216,914.91	33,510,764.90
210201	Тэтгэврийн даатгал	18,789,676.29	23,173,437.47
210202	Тэтгэмжийн даатгал	2,185,144.14	2,583,803.69
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,748,114.28	2,312,042.90
210204	Ажилгүйдлийн даатгал	408,545.04	494,680.12
210205	Эрүүл мэндийн даатгал	4,085,435.16	4,946,800.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,106,146.00	32,492,293.00
210301	Гэрэл, цахилгаан	1,746,166.00	2,414,423.00
210302	Түлш, халаалт	8,289,980.00	29,707,870.00
210303	Цэвэр, бохир ус	70,000.00	370,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,670,295.00	20,808,645.00
210401	Бичиг хэрэг	949,550.00	2,182,400.00
210402	Тээвэр, шатахуун	6,111,445.00	11,394,665.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,086,800.00	1,698,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,022,500.00	2,434,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	3,098,480.00
2105	Нормативт зардал	18,871,917.50	68,058,326.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,225,200.00	59,659,956.00
210502	Хоол, хүнс	3,377,947.50	5,922,370.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	268,770.00	2,476,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,583,000.00	11,511,040.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	147,000.00	7,259,700.00

Хангал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210604	Урсгал засвар	1,436,000.00	4,251,340.00
2107	Томилолт, зочны зардал	618,000.00	937,000.00
210702	Дотоод албан томилолт	618,000.00	937,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,596,653.00	125,950.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,164,653.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	54,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	38,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	33,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,317,928.00	10,107,601.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,317,928.00	10,107,601.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,721,252.59	24,496,107.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	24,488,500.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	23,688,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	800,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,721,252.59	7,607.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,721,252.59	7,607.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	2,038,000.00	7,449,849.10
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,038,000.00	5,685,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,038,000.00	5,685,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,038,000.00	5,685,400.00
222001	Тоног төхөөрөмж	2,008,000.00	4,335,400.00
223001	Бусад хөрөнгө	30,000.00	1,350,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(2,038,000.00)	(5,685,400.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	1,764,449.10
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,764,449.10

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	382483300.00	370658430.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	382483300.00	367412830.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	381683300.00	366612830.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	246970300.00	241257762.00
210101	Үндсэн цалин	152918100.00	148657298.00
210102	Нэмэгдэл	71166000.00	71127219.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4536000.00	3123171.00
210104	Урамшуулал	18350200.00	18350074.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33341000.00	31487080.01
210201	Тэтгэврийн даатгал	23462199.99	21791256.86
210202	Тэтгэмжийн даатгал	2469700.00	2423427.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	1975800.00	2183742.05
210204	Ажилгүйдлийн даатгал	493900.01	462604.90
210205	Эрүүл мэндийн даатгал	4939400.00	4626048.58

Хангал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32493900.00	32492293.00
210301	Гэрэл, цахилгаан	2416000.00	2414423.00
210302	Түлш, халаалт	29707900.00	29707870.00
210303	Цэвэр, бохир ус	370000.00	370000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18619000.00	16618500.00
210401	Бичиг хэрэг	1250000.00	1250000.00
210402	Тээвэр, шатахуун	12559700.00	10559700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,486,800.00	1,486,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,022,500.00	2,022,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,300,000.00	1,300,000.00
2105	Нормативт зардал	32,690,000.00	28,871,744.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,800,000.00	23,736,666.00
210502	Хоол, хүнс	6,940,000.00	3,729,078.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,950,000.00	1,406,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,500,000.00	5,163,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,000,000.00	3,669,900.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,494,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,500,000.00	488,000.00
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	488,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,485,000.00	125,950.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	110,000.00	54,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	187,500.00	38,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	35,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,350,000.00	-
210807	Газрын төлбөр	40,500.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	30,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,084,100.00	10,107,601.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,084,100.00	10,107,601.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	800,000.00	800,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	800,000.00	800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	800,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	3,245,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	3,245,600.00
222001	Тоног төхөөрөмж	-	1,895,600.00
223001	Бусад хөрөнгө	-	1,350,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	382,483,300.00	371,567,080.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	318,139,400.00	318,139,400.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	318,139,400.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	318,139,400.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	35,343,900.00	35,343,900.00
132001	Орон нутгийн төсвөөс	35,343,900.00	35,343,900.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	29,000,000.00	18,083,780.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	29,000,000.00	18,083,780.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		901,042.99
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	1.00	-
620001	Удирдах ажилтан	1.00	-
620002	Гүйцэтгэх ажилтан	-	-
620003	Үйлчлэх ажилтан	-	-
620004	Гэрээт ажилтан		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон		/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	94,362,458.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	91,922,658.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	68,234,158.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,037,607.00
210101	Үндсэн цалин	16,037,607.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,023,684.89
210201	Тэтгэврийн даатгал	1,382,180.61
210202	Тэтгэмжийн даатгал	160,376.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	128,300.85
210204	Ажилгүйдлийн даатгал	32,075.22
210205	Эрүүл мэндийн даатгал	320,752.14
2104	Хангамж, бараа материалын зардал	4,190,145.00
210401	Бичиг хэрэг	932,400.00
210402	Тээвэр, шатахуун	834,965.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	212,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	412,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,798,480.00
2105	Нормативт зардал	39,186,582.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	35,923,290.00
210502	Хоол, хүнс	2,193,292.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,070,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,347,140.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,589,800.00
210604	Урсгал засвар	2,757,340.00
2107	Томилолт, зочны зардал	449,000.00
210702	Дотоод албан томилолт	449,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,688,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,688,500.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	23,688,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,439,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,439,800.00
222001	Тоног төхөөрөмж	2,439,800.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	95,225,865.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	95,225,865.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,751,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	88,743,465.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,731,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	863,406.11

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хангал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны баримт бүрдүүлэлтийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 2 дугаар сарын 15-аас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Сувдаа гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хэрэгжүүлсэн.

Хангал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 01/06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго нь Байгууллагын бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгон, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг стандарт технологийн дагуу үзүүлж тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулж иргэдийг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, мэдлэг хандлагыг нэмэгдүүлэхэд оршино. Зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажиллажээ. Үүнд:

- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг мэдээлэл технологийг ашиглан сайжруулах.
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулан иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлагналдаа мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг аймгийн Засаг даргын А/424 тоот захирамжаар 2020 онд батлуулж Төсвийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлэн Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”-ыг тусгасан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хангал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 354,420.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 5,316.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг тайлант үеийн нийт зардлаас 1.5 хувиар буюу 6,975.3 мянган төгрөгөөр материаллаг байдлаар тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хангал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 91,082.5 мянган төгрөгөөр буюу 26.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, эм боох материал, аж ахуйн материал, машин тоног төхөөрөмж, ажилчидтай холбоотой өглөг, бараа үйлчилгээний зардлын өглөг, тайлант үеийн үр дүн болон үндсэн хөрөнгийн элэгдэл данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	1764.4	1764.4
Урьдчилж гарсан тооцоо	0.0	55326.1	55326.1
Бараа материал	34670.8	67901.7	33230.9
Үндсэн хөрөнгө	307603.4	308364.5	761.1
Нийт хөрөнгө	342274.2	433356.8	91082.5
Өр төлбөр	0.0	27125.8	27125.8
Хуримтлагдсан үр дүн	342274.2	406231.0	63956.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	342274.2	433356.8	91082.5

Дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ЭМДХ-ээс 55,326.1 мянган төгрөгийн авлага нэмэгдсэн,
- Эм боох материал ковид-19 цар тахал гарсантай холбоотойгоор 17,250.8 мянган төгрөгөөр өссөн;
- Аж ахуйн материал 15,025.4 мянган төгрөг, Машин тоног төхөөрөмж 25,821.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн;
- ЭМДХ-ээс санхүүжилт дутуу орсноос өглөг 26,725.7 мянган төгрөгөөр өссөн,
- Тайлант үеийн үр дүн 63,755.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн;

- Үндсэн хөрөнгө данс тайлант оны элэгдлийн зардлаас голлон шалтгаалж 17,279.1 мянган төгрөгөөр буурсан;

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт	Хувь
1	Үйл ажиллагааны орлого	332,437.83	664,581.97	332,144.14	100%
11	Татварын орлого	-	-	-	
12	Татварын бус орлого	19,183.34	143,064.52	123,881.18	646%
120004	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	6,755.26	-	(6,755.26)	-100%
122	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	-	-	-	
13	Тусламж, санхүүжилтийн орлого	313,254.49	521,517.45	208,262.96	66%
1310	Улсын төсвөөс санхүүжих	280,708.20	318,139.40	37,431.20	13%
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,700.00	149,950.37	139,250.37	1301%
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	11,663.20	35,343.90	23,680.70	203%
1330	Төсвийн захирагчаас	-	-	-	
1340	НДС-аас санхүүжих	10,183.09	18,083.78	7,900.69	78%
14	Бусад эх үүсвэр			-	
2	Үйл ажиллагааны зардлын дүн	352,155.01	600,826.68	248,671.68	71%
21	Урсгал зардал	352,155.01	600,826.68	248,671.68	71%
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	345,433.75	576,330.58	230,896.82	67%
211	Хүү	-	-	-	
212	Татаас	-	-	-	
213	Урсгал шилжүүлэг	6,721.25	24,496.11	17,774.85	264%
22	Хөрөнгийн зардал	-	-	-	
3	Үйл ажиллагааны үр дүн /3=1-2/	(19,717.17)	63,755.28	83,472.46	-423%
145	Үйл ажиллагааны бус орлого	-	-	-	
225	Үйл ажиллагааны бус зардал	2,429.10	-	(2,429.10)	-100%
4	Үйл ажиллагааны бус үр дүн /4=145-225/	(2,429.10)	-	2,429.10	-100%
5	Нийт үр дүн /5=3+4/	(22,146.27)	63,755.28	85,901.56	-388%

Хангал сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нэмэлт санхүүжилтийн орлого өмнөх оноос 139,250.4 мянган төгрөг буюу 1.3 дахин өссөн, нийт орлого 332,144.1 мянган төгрөгөөр буюу 1.0 дахин өсөж төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Хангал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүжилтийн эх үүсвэрийг 396,802.3 мянган төгрөг, үүнээс урсгал зардалд 396,802.3 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Сангийн яамнаас урсгал зардлыг 13,819.0 мянган төгрөгөөр бууруулан 382,983.3 мянган төгрөгөөр баталж тодотголоор 500.0 мянган төгрөгөөр бууруулж 382,483.3 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 318,139.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 35,343.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, ЭМДС-аас 29,000.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр үндсэн дансаар улсын төсвөөс 318,139.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 35,343.9 мянган төгрөг, ЭМДС-аас 18,083.8 мянган төгрөг, нэмэлт дансаар Төрийн болон

болог орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандав, тусламж 1,3751.4 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 88,1743.5 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд 4,731.0 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч, нийт 465,020.9 мянган төгрөгийн зарцуулалт хийснээс үндсэн дансаар 370,658.4 мянган төгрөгийг зарцуулж 7.6 мянган төгрөгийг төвлөрүүлж, 96.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 370,658.4 мянган төгрөг буюу 96.9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 5.712.5 мянган төгрөг, ажил олгогчийн НДШ 1,853.9 мянган төгрөг, хангамжийн бараа материалын зардал 2,000.5 мянган төгрөг, норматив зардал 3,818.3 мянган төгрөг, томилолтын зардал 1,012.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлыг 2,359.1 мянган төгрөгөөр тус тус дутуу, хөрөнгийн зардалд 3,245.6 мянган төгрөгийг зарцуулснаас шалтгаалсан байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулалт нь үйл ажиллагааны урсгал зардал 15,070.5 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт-3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71602	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	491,896.17	465,020.89	26,875.28	94.5%
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	378,220.77	352,221.46	25,999.31	93.1%
1.2	80109	ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	33,993.90	33,986.29	7.61	100.0%
1.3	80302	Нэг иргэнд ногдох нормативаар	56,681.50	55,813.14	868.36	98.5%
1.4	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	23,000.00	23,000.00	-	100.0%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгийн бүртгэлд байгаа үлдэх өртөггүй элэгдлээ бүрэн нөхсөн хөрөнгийг өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх

3.8 Аудитын гол асуудал

Хангал сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан local.audit.mn цахим бүртгэлийн хүрээнд мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хангал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 онд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын нийт 493,331.2 мянган төгрөгийн 29 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас орлогын 353,510.6 мянган төгрөгийн 16, зарлагын 17,878.4 мянган төгрөгийн 2 мэдээллийг ил тод байршуулаагүй зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Коронавируст халдвар тархсантай холбоотойгоор тайлант онд Эрүүл мэндийн сайд, сангийн сайдын А/337,99 67/А/268 хамтарсан тушаалаар хоёр удаагийн журам, Эрүүл мэндийн сайдын А/605 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс 03, 04 дүгээр тоот тогтоолоор “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай”, Эрүүл мэндийн сайдын А/248, А/415 тоот тушаалаар илүү цагаар ажилласны нэмэгдэл, А/496, А/585 тоот тушаалаар мөнгөн тэтгэмж олгох, А/575, А/581 тоот тушаалаар хөрөнгө гаргах, А/788 тоот тушаалаар эрх шилжүүлэх, А/803 тоот тушаалаар нэг удаагийн мөнгөн урамшуулал олгох тус тус шийдвэрийг гаргасан байна.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудит хийгдээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагыг биелүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 55.9 хувьтай байна.

Хүснэгт-4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	400.3	1	400.3	0	0	0
Албан шаардлага	5	44433.7	5	44433.7	0	0	0
Зөвлөмж	4	13255.6	2	5845.9	2	7409.7	44.1
Нийт дүн	10	58089.6	8	50679.9	2	7409.7	12.8

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн НӨАТ-тай худалдан авалт хийх, харилцагч байгууллага, иргэнтэй тооцоо нийлж баталгаажуулах зөвлөмжийг давтан гаргасан тул албан шаардлага хүргүүлээ.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн эсэхийг нягтлах, биелэлтийг тооцох.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 19,986.6 мянган төгрөгийн 10 алдаа зөрчил илэрснээс, 15,605.0 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 629.8 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт, 3,150.2 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 601.6 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 7 алдаа, зөрчлийн дүн 4,381.6 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 6,975.3 мянган төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Бараа материалын зарцуулалтын журнал бүртгэлийг алдаатай бүртгэсэн;
- Тайлант хугацаанд үүссэн 3,170.0 мянган төгрөгийн авлагын журнал бүртгэлийг данс буруу бүртгэсэн,
- Өглөг үүсгэн бүртгэхдээ 8,725.4 мянган төгрөгөөр алдаатай журнал бүртгэл хөтөлсөн

4.2 Төлбөрийн акт

1. Сумын Засаг даргын захирамжаар 18 орон тоотой ажиллахаар баталж батлагдсан орон тоонд хавсран ажилласны нэмэгдлийг олгохдоо хавсран ажиллаж буй албан тушаалын цалингийн шатлалаас олгоогүйгээс 229.8 мянган төгрөгийн үргүй зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон 229,810.50 төгрөгийг орон нутгийн орлого болгох, Төлбөрийн акт тогтоох

2. Эрүүл мэндийн төвийн дарга сумын Засаг даргын захирамжгүйгээр өөрөө 2021 оны 08 дугаар сарын 05-ны Б/20, 10 дугаар сарын 13-ны Б/25 дугаар тушаалаар 400.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4.2 -т "хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд урамшуулах, хариуцлага тооцох" заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Эрх зүйн үндэслэлгүй олгосон 400,000.0 төгрөгийг орон нутгийн орлого болгох, Төлбөрийн акт тогтоох

4.2 Албан шаардлага

1. Тайлант хугацаанд иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримтгүй нийт 20,527,897.32 төгрөгийн худалдан авалт хийсэн, харилцагч 23 байгууллага, иргэнтэй тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй, өмнөх оны зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заалтыг хэрэгжүүлж байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, холбогдох хууль, тогтоомжийг бүрэн хэрэгжүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах, Албан шаардлага өгөх.

2. Тайлант онд цалинг тооцон олгохдоо НДШ, ХХОАТ-ын өглөгийг шууд, НДШ-ийг цалингийн өглөг данс руу нийт 3,150.2 мянган төгрөгийн журналын бүртгэл буруу хөтөлж өглөгийн дансаар дамжуулаагүй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 5.10-т заасныг хэрэгжүүлээгүй, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож холбогдох стандарт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасны дагуу журналыг хөтөлж зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах, Албан шаардлага өгөх.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

ЭМГ-аас ирсэн бараа материалыг орлогод авахдаа тухай бүр орлого авдаггүй, ЭМГ-тай тооцоо нийлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 16.5.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д заасныг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх

2. Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант хугацаанд тооцооллыг тухай бүр хийгээгүйгээс 601.6 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэснийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх

3. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 16 удаагийн 353,510.6 мянган төгрөгийн орлого, 2 удаагийн 17,878.4 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг шилэн дансанд мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
				Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тэшиг сумын Эрүүл мэндийн төв	10	19,986.6	3	15,605.0	2	629.8	2	3,150.2	0	0	3	601.6